

МУБИС- БАГШИЙН СУРГАЛТЫН АЖЛЫН АРГА БАРИЛЫГ СУДЛАХ МЕНЕЖМЕНТИЙН УХААНЫ АРГА ЗҮЙН ҮНДЭС

Ч.Пүрэвдорж

Боловсролын удирдахуйн ухааны тэнхим

Хувьсан өөрчлөгдөж буй орчин, түүнд дасан зохицох тухай ойлголт орчин цагийн менежментийн хөгжлийн мөн чанарыг илэрхийлж байна. Улс төр, эдийн засаг, хүн ам мэтийн макро орчинд гарсан өөрчлөлт боловсрол зэрэг бусад супер тогтолцоо хэрхэн оршихын утгвар нөхцөл болно. Энэ зүй тогтлыг тогтолцооны онол, тогтолцооны шинжилгээнд тулгуурлан судалдаг. Тогтолцооны бүхэллэг, иерархи, динамик, синергетик зэрэг олон шинж чанарыг байгаль, техникийн ухаан нээн илрүүлсээр байна. Манай орны тухайд Боловсрол судлал шинжлэх Улааны салбар болохын хувьд арга хэлбэрээ төдийлөн сайн олж амжаагүй; бихейворизм хийгээд коммунист хүмүүжлийн онолд суурилсан сурган хүмүүжүүлэх ухаан үеэ өнгөрөөсөн: олон улсын хэмжээнд тогтсон сургалтын уламжлалт онолыг судалж эзэмших эхэн үед яваа зэрэг хүчин зүйлээс шалтгаалж боловсролын аливаа судалгаанд шинжлэх ухааны суурь зарчим арга зүй нэн чухал болсоор байна. Тийм суурь зарчмын нэг нь шинжлэх ухааны менежмент юм. Энэ удаад багшийн сургалтын ажлын арга барилд менежментийн ухааны үүднээс хандах ямар бололцоо байж болох вэ гэдгийг эргэцүүлэхийг оролдсон болно. Багшийн ажил шинжлэх ухаанд үндэслэхийн хамт урлаг, уран сайхны сэтгэхүйд ихээхэн хэмжээгээр тулгуурладаг учраас түүнд бүтээлч эргэцүүлэл (Reflection) нэн чухал юм. Хэрэв манай багш нар бүтээлч эргэцүүлэлтийг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж сэтгэхүй, арга барилдаа өөрчлөлт гаргаж чадвал тэдэнд онолын мэдлэг тэр бүр дутахгүй бөгөөд боловсролын шинэчлэл үйл ажиллагааны хүрээнд хэрэгжих үндэс суурь бүрдэж хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ гэдэг утга агуулга руу жинхэнэ утгаараа орох болов уу.

Багш, суралцагчийн оновчтой сайн харилцаа сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах сургуулийн амьдралын чухал хүчин зүйл юм. Багш, шавийн барилдлага суларч байна. Хүүхэд багшдаа хүндэтгэлгүй ханддаг болсон гэж сэтгэл зовнисон хүмүүс сүүлийн үед цөөнгүй тохиолдох болжээ. Үүнтэй холбоотойгоор:

- Номын багшаа хүндэтгэн мөнх барилдлагатай явах уламжлал суларсан уу .
- Монгол хүний ёс жудаг бүдгэрсэн үү
- Хүүхдийн нийгэмшил, ёс зүй дордсон уу мэтийн олон асуулт гарна.
- Багшаа хүндэтгэх эл асуудалд нөгөө талаас нь бас хандаж болох юм. Тухайлбал:
- Багш нь шавийнхаа хүндэтгэлийг хэзээ хүртэх вэ
- Багш алдар хүндлэлийг тэднээс хүсэн хүлээсээр суух уу
- Багш тийнхүү хүндлүүлэхийн тулд юу хийх ёстой вэ мэт асуулт бас гарна.

Эдгээр хоёр талтай олон асуултын учрыг шинжлэх ухаанд тулгуурлан эрэлхийлэх нь түүний үнэн зөв шийдэд дөхөх хамгийн дөт зам байж мэдэх юм. Багшийг менежер гэх онол баримтлал бий. Тэгвэл менежер гэж хэнийг хэлэх вэ, түүнийг шинжлэх ухааны менежментэд хэрхэн үндэслэсэн байдаг вэ. Ном сурах бичигт дурдсаныг тоймлон үзвэл менежер нь:

- Менежментийн ухаанаар мэргэшсэн
- Менежерийн албан тушаал дээр ажилладаг
- Менежерийн стандарт, ёс зүйг сахидаг гэх зэрэг үндсэн шалгуурыг тоочсон байдаг.

Ардчилал, зах зээлийн орчинд хүмүүсийг шинжлэх ухааны менежментэд үндэслэн удирдах нь нотолгоогүй үнэн зүйл юм. Багш бол сургалтыг хөтлөн удирддаг гэдэгтэй хэн хүнгүй санал нийлэх нь тодорхой. Тэгвэл өнөөгийн Монгол улс түүний өсвөр үеийнхнийг ардчилал, зах зээлээс ангид сэтгэх боломжгүй бөгөөд тэдний анги танхимын сургалтыг менежментийн ухаанд үндэслэн

удирдахаас өөр аргагүй юм. Багш нар маань ч менежер гэгдэхээс өөр замгүй. Энэ нь мэдээжийн хэрэг багшийн албан тушаалыг менежер болгочих гэсэн үг хараахан биш харин багш бүр менежментийн ухаанд суралцаж сургалтын үйл ажиллагаа түүний онол баримтлал, арга ухаанд тулгуурлахыг хэлж буй юм. Ийм байр сууринаас хандвал сургууль багш нарын сургалтын үйл ажиллагаанд олон шинэ зүйл хөндөгдөх нь ойлгомжтой. Боловсролын тогтолцоог шинэчлэхээр тасралтгүй шүүмжилж байгаа иргэдийн хэрэгцээ сонирхлын нэлээд хэсэг нь чухамхүү үүнтэй холбоотой байж ч мэдэх юм. Тийм учраас менежментийн ухаанд суралцах явдал боловсролын шинэчлэлийн нэгэн амин чухал асуудал мөн.

Жишээ болгох, санаа авхуулах үүднээс багшийн ажлын менежментэд холбогдох нэгээхэн асуудлыг энд өнгөц боловч хөндөгөө. Сурагч багшдаа хүндэтгэлтэйгээр хандах асуудлыг дээр өгүүлсэн. Тэгвэл эл асуудлыг менежментийн үүднээс менежерийн ажлын арга барил, хошуучлах чадвартай холбож үздэг.


Хошуучлалын онолын гурван хандлага бий. Үүнд:

- Хувийн шинж чанарын хандлага .
- Зан үйлийн хандлага .
- Ситуацийн хандлага.

Багшийн сургалтын ажлын арга барилыг судлахад эдгээр онолын дотроос зан үйлийн хандлагыг хэрхэн ашиглах боломж байна вэ гэдгийг хамтдаа эрэлхийлцгээ.

Зорилгоо хэрэгжүүлэхээр хүмүүст нөлөөлөх, өдөөхийн тулд тэдэнд хандах удирдагчийн зан үйлийн ерийн байдлыг удирдлагын арга барил гэж ойлгодог. Бүрэн эрхээ төлөөлөн шилжүүлсэн байдал, засаглах хэлбэр, хүмүүст хандах хүмүүнлэг харилцаа бүгдээрээ удирдлагын арга барилд хамаарна. Багшийн сургалтын ажлын арга барилыг автократ (захирангуй), либерал (эвлэрэнгүй) гэсэн хоёр туйлтай, тэдгээрийн дунд ардчилсан арга барил оршдог гэж төсөөлье. Тэгвэл багшийн сургалтын ажлын арга барилын континум нэгдүгээр зурагт үзүүлсэн хэлбэртэй байна.

Зураг 1 Багшийн арга барилын континум



Автократ арга барилтай багш захиран тушаах шинжтэй. Тэрээр хүүхдэд санаа бодлоо тулган хүлээлгэх замаар харьцдаг. Ийм багш хүрэлцэхүйц хэмжээний засаглалтай байхыг эрмэлзэнэ. Тэд юуны өмнө шалгалт шүүлгээр далайлган, эцэг эхэд нь хэлнэ, хурлаар оруулна гэх зэргээр сүрдүүлэх түүгээр ч зогсохгүй загнах, шоглох мэтээр хүчирхийлэхээс ч буцахгүй зан үйлийн хандлага давамгайлна. Автократ багш хүүхэдтэй харьцахдаа урьдал болгодог баримтлалыг хошуучлалын судалгаагаар нэрд гарсан Дуглас МакГрегори "Х" онолыг баримтлан илэрхийлбэл:

- Хүүхэд хичээллэх дургүй болж өгвөл түүнээс зугтаадаг
- Хүүхэд залхуу учраас тэднийг албадаж, сүрдүүлж, захирч, хянаж байвал зохино
- Хүүхэд бэлэнчлэх, хариуцлагаас зайлсхийх бас шударга бус хандлагад хялбархан өртдөг
- Хүүхдийг захирч тэдэнд юу сурахыг нэг бүрчлэн зааж өгөх ёстой
- Цөөхөн хүүхэд үнэн голоосоо хичээдэг
- Хүүхдийн оюун ухааны хязгаарлагдмал чадвар нь шинжлэх ухаанд суралцах боломжийг мөхсөдүүлдэг

- Хүүхэд өөртөө итгэл муутай эсвэл онгиргон хөөрүү байдаг

Ийм баримтлал бүхий арга барилтай багш ихэвчлэн сургалтын бихейворист онолыг баримталж, бүрэн эрхийг аль болохуйц төвлөрүүлж хүүхдийг захиран хянаж тэд асуудлаа өөрөө шийдэх боломжийг хязгаарладаг байна.

Харин Либерал арга барилтай багш автократаас зарчмын ялгаатай нь Мак Грегорын “у” онолоос тодорхой харагдана. Тухайлбал:

- Хүүхэд хичээллэх угийн дургүй биш сургалтын сайн нөхцөл, сайн харилцааг эерэгээр хүлээн авна
- Оөрсдөө оролцож хүлээн авсан мэдлэгээ чадвар болгож өөрийгөө идэвхжүүлж өөрийгээ идэвхжүүлж өөрийгөө захирч чаддаг
- Хүүхэд хариуцлага хүлээхэд суралцаж чадна
- Ихэнх хүүхэд бүтээлч чанар, мэргэн ухаан, нэр хүндтэй байх чадвартай
- Сургалтын агуулга сонирхолгүй, нас биеийн онцлогт нийцээгүй учраас тэдний идэвх санаачилгыг боогдуулдаг
- Хүүхэдтэй хүүхэд мэт харьцаж ганцаарчлан ажиллаж итгэл хүлээлгэвэл сайн суралцах бүрэн үндэстэй
- Орчин цагийн сургалтын орчин, нөхцөл хүүхдийн мэдлэг, чадварыг бүрэн дүүрэн ашигладаггүй

Энэхүү баримтлалаар бол багш хүүхдийн өөрийгөө илэрхийлэх түүний дээд эрэмбийн хэрэгцээг эрхэмлэж байна. Либерал арга барилтай багш хүүхдэд санаа бодлоо тулгахаас зайлсхийж хамтран хэлэлцэхийг чухалчилж сурагчдынхаа санал бодлыг хүндэтгэдэг. Үүний үрээр сургалтад хүүхдийн оролцоо, гүйцэтгэх ажлын эрх чөлөө нэмэгдэж багшийн хошуучлах боломж сайжирч суралцагч багшаа хүндэтгэх түүнчлэн багш шавийн барилдлагын эерэг үндэс бүрдэнэ. Энэ бүхэн бол онолын үндэс ерөнхий зүй тогтол юм. Үүнийг манай өнөөгийн амьдрал дээр судалж үзэх хэрэгтэй. Бид Архангай, Говь-Алтай, Увс, Дундговь, Дорнод, Хэнтий зэрэг 15 аймгийн 89 сумаас ирсэн 116 багш, сургуулийн удирдах ажилтантай хамтран судалгаа хийж хэлэлцүүлэг хийж үзэхэд манай багш нарын ажлын арга барил, хошуучлалын талаар илэрхийлэх түүний дор дурдсан хандлага ажиглагдаж байв.


Багшийн ‘Х’ хандлага	Багшийн ‘У’ хандлага
-Юу хийхийг нь зааж өгөхийг хичээдэг -Санаачилга багатай -Заавраар ажиллахыг чухалчилдаг -Захиран тушаахыг урьдал болгодог -Харилцах чадвар сул -Цаг ашиглалт муу -Бусдын талаар буруу ойлголт өгдөг -Шунамгай -Албан тушаалд дуртай -Нээлттэй биш -Заах арга барил муу -Орчиндоо дасан зохицох чадвар сул -Ихэмсэг -Гадаад үзэмждээ анхаардаггүй -Өөрийнхөөрөө зүтгэдэг -Үзэл бодлоо тулгадаг -Шаардлага сайнтай	-Нэр хүндтэй -Өөрийгөө хөгжүүлдэг -Санаачилгатай -Цагийг үр бүтээлтэй өнгөрөөдөг -Хариуцлагатай -Санаанд хүрсэн зүйлээ сайн хийдэг -Ажилдаа сонирхолтой -Оюунлаг -Урамшуулалд дуртай -Алдаагаа хүлээн зөвшөөрдөг -Хүний төлөө гэсэн сэтгэлтэй -Нийтэч -Шүүмжлэл хүлээж авдаг -Сурагчдын авьяас чадварыг бүрэн илрүүлж чаддаггүй -Шаардлага султай

Судалгааны нэгдсэн үнэлгээний дүнгээс үзэхэд энд дурдсан багшийн ажлын арга барилын чиг хандлага чухал боловч багшийн ажлын арга барилд ийм нийтлэг зүй тогтол байгааг багш нар өөрсдөө хүлээн зөвшөөрсөн нь анхаарал татна.

Хошуучлалын талаар дээр үеэс судалгаа хийсэн эрдэмтдийн нэг бол Курт Левин юм. Левин судалгаа хийхдээ 10 настай хөвгүүдийг хэд хэдэн бүлэг болгоод тэдгээрийн ахлагчаар автократ, либерал арга барил бүхий насанд хүрэгчдийг тавьжээ. Laissez-faire – гэдэг франц үг "Бүү оролд, орхи" гэсэн утгатай юм байна. Либерал удирдагч иймэрхүү зарчмыг баримталдаг. Тэр захирагдагчдад зорилтоо тодорхойлох, хянахад бараг бүрэн эрх чөлөө өгдөг. Автократ удирдагч либералыг бодвол илүү их ажил хийлгэсэн нь Левиний хийсэн судалгаанаас харагджээ. Харин Левиний туршилтын автократ удирдлагатай бүлгийн хүүхдүүд мотиваци бага, чин санаагүй, нөхөрсөг байдал бага, бүлгийн сэтгэхүй байхгүй, илүү хэрцгий, бусдаас хамаарсан бас түгшүүртэй байжээ. Либерал удирдлагын үед ажлын хэмжээ, чанар аль аль нь буурсан байна. Энэ бол удирдагчийн арга барилын талаарх туршилтын нэг баримт бөгөөд үүнд тайлбар хийх нь илүүц болов уу.

Мичиганы их сургуулийн профессор Рэнсис Лайкарт нөхдийнхээ хамт хүмүүсийн янз бүрийн бүлгийг харьцуулан судалж удирдлагын арга барилын талаар өөр нэг хувилбар санал болгосон байдаг. Удирдлагын арга барил ямарч тохиолдолд эсвэл ажилд, эсвэл хүнд төвлөрсөн чиг хандлагатай байдаг гэсэн дүгнэлтийг Лайкарт хийжээ. Түүнийг үндэслэн багшийн ажлын арга барилын нэг туйл нь сургалтанд ("Х" онол) нөгөө нь хүүхдэд ("У" онол) төвлөрдөг гэж болно (Зураг 2).

Зураг 2 Лайкертын континуумд үндэслэсэн багшийн арга барил



Ийнхүү эсвэл ажлаа боддог эсвэл хүнээ боддог хоёр хандлагын аль алийг зохих хэмжээгээр нэгэн зэрэг баримтлах боломж үндсэндээ байхгүй юм. Удирдлагын арга барилыг хүмүүст ба ажилд төвлөрсөн гэж эрс заагладаг баримтлал алдаатай болохыг олон судлаач анзаарч ситуацийн хандлага гэдэг шинжлэх ухааны шинэ чиглэл бий болгожээ.

Ситуацийн шинжилгээнд дор дурдсан онол - загварыг голчлон хэрэглэсэн байдаг. Үүнд:

- Фидлерийн ситуацийн загвар .
- Герси Бланчардын мөчлөгийн онол
- Митчел, Хаусийн "Зам-зорилго" гэсэн хандлага .
- Врум - Йеттоны удирдагчийн шийдвэр гаргах загвар зэрэг болно.

Эдгээр онол баримтлалаас харахад багшийн сургалтын ажлын арга барилыг автократ, либерал эсвэл сургалтад төвлөрдөг, хүүхдэд төвлөрдөг гэх нь харьцангуй ойлголт юм. Энэ нь ОЛОНх тохиолдолд давтагддаг ерөнхий хандлагыг илэрхийлэхээс биш хэн, хэзээ, хаана, ямар нөхцөлд гэх мэтээс шалтгаалах ситуацлаг шинжтэй. Хэрэв үүнийг туйлшруулбал хилсдүүлэг хэлмэгдүүллийн хэрэгсэл болгох үндэс байдгийг сайтар анхаарах нь чухал юм. Тийм учраас багшийн сургалтын ажлын арга барилыг ситуацийн талаас нь нарийвчлан судлах хэрэгтэй.

Сүүлийн хорь шахам жилд хэрэгжүүлсэн шинэчлэлийн үр дүнд боловсролын үйлчилгээнд оролцогчдын хуучин хандлага өөрчлөгдөж бүх чиглэлд шинэ уур амьсгал орж байна. Үүний гол үр дүн нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн иргэдийнхээ хүсэл сонирхлыг хангахуйц боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх явдал гэдгийг хүлээн зөвшөөрсөнд оршино. Энэхүү чанартай үйлчилгээ олон зүйлээс шалтгаалах нь мэдээж. Гэхдээ тэрхүү үйлчилгээг үзүүлдэг багш нарын сургалтын

ажлын арга барил, хошуучлал үүнд шийдвэрлэх үүрэгтэйг дахин хэлмээр байна. Юу заах вэ, Юу сурах вэ, Сурсан зүйлээс юуг нь хэрхэн шалгах вэ гэсэн асуудалд төвлөрсөн кинрикулим, стандартыг голчлох нь зүй ёсны боловч хэрхэн заах вэ гэдгийг зөвхөн дидактикаар хязгаарлаж боломгүй. Орчин цагийн сургалтын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд багш, сурагчид харилцаа хошуучлал, мотиваци, коммуникаци, багшийн имиже зэрэг олон асуудалд анхаарал тавих нь нэн чухал болов.

Мэдээллийн эх үүсвэр

- Ч.Пүрэвдорж Байгууллагын менежмент (Сурах бичиг), 65 хэвлэлийн хуудас, 2006 Пүрэвдорж Ч.Боловсролын хөгжлийн онол арга зүйн асуудалд.- УБ.1999.
- Денисов А.А. Теоретические основы кибернетики.-Л.:ЛПИ, 1975.
- Друкер П.Ф.Задачи менеджмента в XXI веке. Пер. с англ. М.: Вильямс, 2000.
- Мелентьев Л.А.Оптимизация развития и управление больших систем энергетики. - М: В. Школа, 1982.
- Хакен Г.Синергетика. Иерархии неустойчивостей в самоорганизующихся системах и устройствах. Пер. с англ. -М.:Мир, 1985.
- Шахмалов Ф.И.Американский менеджмент. М.: Наука, 1993.
- Литер Ф.Друкер Задачи менеджмента в XXI веке: Перс англ.-Вильямс, 2001.
- Andrew, P.Reflective Teaching, 2nd Edition Continuum, London, New York, 2005.
- Beohnke, K., Distefano, C.A., Distefano, J.J,Bontis, N.Leadership for extraordinary performance Iyey Business Quarterly. [Online]. Available:<http://proquest.umi.com>.
- Bonney, R.Management Guidelines for Teachers, Great Britain at The Bath Press, Avon Douglas McGregor The Human Side of Enterprise 1960.
- Patrick J. Montana, Bruce H. Charnow, Management Third edition, Barron's, 2000.